

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон

# Тэнгэрлэг Эцэгийн гайхалтай төлөвлөгөө

Бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө бол *гайхалтай*. Энэ амьдралд бидний хийх зүйл үнэхээр чухал. Аврагчийн Цагаатгал Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг боломжтой болгодог.

Аврагч зовсон учир биднийг хэрэгтэй үед тайтгаруулж, эдгээж, аврах боломжтой болсон билээ. Есүс Христийн хязгааргүй Цагаатгалын ачаар Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөө төгс төгөлдөр болсон билээ! Энэ нь *бидний* хүн нэг бүрд *хэрхэн* амьдрах сонголтыг хийх боломж олгодог.

Би та нарыг "**Селестиел ухаанаар бодож**" эхлэхэд урьж байна! Та нар асуудалд орвол селестиел ухаанаар бодогтун! Уруу таталтад орохдоо ч селестиел ухаанаар бодогтун! Амьдрал эсвээс таны хайртай хүмүүс урмыг тань хугалах үед селестиел ухаанаар бодогтун!

Та нар селестиел ухаанаар бодох үедээ илүү ойр ойрхон, чин сэтгэлээсээ залбирахыг хүснэ. Та нар сорилт бэрхшээлийг өөр өнцгөөс харах болно. Та нар селестиел ухаанаар бодох үед итгэл найдвар тань өсөн нэмэгдэх болно.

Бурхан амьд. Есүс бол Христ. Бурханы бүх хүүхдийг адислахын тулд Түүний Сүм сэргээгдсэн.

"ЕСҮС ХРИСТИЙГ НЭГТ ТАВЬ. УЧИР НЬ ТА НАРЫН МӨНХИЙН АМЬДРАЛ ТҮҮНД ИТГЭХ ИТГЭЛЭЭС ТАНЬ ХАМААРАЛТАЙ."

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон



ЕСҮС ИРЭГТҮН, МАЙКЛ МОМ

**селестиел ухаанаар бодох:**
сүнслэгээр сэтгэж Аврагчийн үлгэр жишээг дагах

*"Селестиел ухаанаар бод!" үгээс авав. Лиахона, 2023 оны 11-р сар, 115–17.*





## Селестиел ухаанаар бодогтун!

**Селестиел ухаанаар бодох нь бидэнд зөв сонголт хийхэд тусалж болохыг ерөнхийлөгч Нэлсон заав. Нар тус бүр дээр Аврагчийн үлгэр жишээг дагахын тулд юу хийж болохоо зурж эсвэл бичээрэй.**

